



ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 4/02

Өмнөдэлгэр сум

2025 оны цэргийн бүртгэл явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл, аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/675 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн бүртгэлийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Л.Баярмаа	Засаг даргын Тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга:	М.Уянга	Архив, бичгийн хэргийн ажилтан
Гишүүд:	С.Батсуурь	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн
	Б.Ууганцэцэг	Улсын бүртгэгч
	Б.Болор-Эрдэнэ	Наран багийн Засаг дарга
	Д.Батболд	Баянзүрх багийн Засаг дарга
	А.Баянмөнх	Хэнтий багийн Засаг дарга
	Г.Нарангэрэл	Талынбулаг багийн Засаг дарга
	Ж.Энх-Амгалан	Чандган багийн Засаг дарга
	Б.Хонгорзул	Төвийн багийн Засаг дарга

2.2025 оны цэргийн бүртгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн 2025 оны 01 дугаар сарын 20-ны өдрүүдэд сумын хэмжээнд зохион байгуулсугай.

3.2024 оны жилийн эцсийн хүн амын тоотой тулган, цэргийн бүртгэлийн материал, мэдээ судалгааг маягтын дагуу гаргаж, тогтоосон хугацаанд хүргэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Баярмаа)-д даалгасугай.



Р.ЭНХТӨР

